



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2015 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 432

Улаанбаатар хот

“Глашиер ассет” ХХК-д үнэт цаасны итгэмжлэн  
удирдах үйл ажиллагаа эрхлэх нэмэлт тусгай  
зөвшөөрөл олгох тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.5, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, 63 дугаар зүйлийн 63.1.5, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.7, 44.7.2 дах хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Глашиер ассет” ХХК-д үнэт цаасны итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх нэмэлт тусгай зөвшөөрлийг олгосугай.

2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргийг биелүүлж ажиллахыг “Глашиер ассет” ХХК /Я.Адьяахүү/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, холбогдох өөрчлөлтийг Хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Э.Мөнхбаяр/-т, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДЭД ДАРГА:



Э.БАТБОЛД